

Биоаюулгүй байдлыг хангах талаар авах
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд “Биоаюулгүйн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд”-ын тухай Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүхийн илтгэл, холбогдох баримт материалтай ажлын журмаар танилцаад ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Монгол Улсын Засгийн газарт:

1. Хувиргасан амьд организм, түүний гаралтай бүтээгдэхүүнийг бүрэн бүртгэлжүүлж мэдээллийн сан бүрдүүлэх, хүнс, эмийн үйлдвэрт хэрэглэх нэмэлт бүтээгдэхүүн, түүхий эдийн бүртгэлийг нэн даруй хийх,
2. Тосны ургамал, шилжмэл гентэй ургамлын тариалангийн нийт талбайд хяналтын тооллогыг 2011 онд хийж бүртгэлжүүлэн, газарзүйн мэдээллийн системд оруулж хянах, хүрээлэн байгаа орчинд нөлөөлөх байдал, болзошгүй эрсдэлийн суурь судалгааг хийх,
3. Лабораториудад биоаюулгүй байдлын зэрэглэл тогтоож, зэрэглэлийн нөхцөлийг хангуулах, биоаюулгүйн дэглэмийг чанд мөрдүүлэх ажлыг 2011 онд зохион байгуулах.